

Safeguarding Kids Together (SKT) Fact sheet for parents and carers

Хүүхдүүдээ Хамтдаа Хамгаалцгаая

Эцэг эх болон асран хамгаалагчдад зориулсан мэдээллийн хуудас

Хүүхдүүдээ Хамтдаа Хамгаалцгаая (SKT) хөтөлбөрийн тухай

Сурагч бүрийг өөрийнхөө бүрэн чадавхи дээр түшиглэн амжилтанд хүрэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор манай сургуулиуд төрөл бүрийн нөөц бололцоогоор хангагдсан байдаг. NSW мужийн бүх улсын сургуулиудад хэрэгждэг SKT хөтөлбөр нь сургуулиудад өндөр эрсдэлтэй нөхцөл байдалд орсон сурагчдыг танин илрүүлэхэд нь туслах зорилгоор мэргэжлийн зөвлөгөө, тусламжийг газар дээр нь авах мөн уг хөтөлбөрт хамрагдах боломжийг олгодог. SKT хөтөлбөр нь дараах зорилготой:

- Бүх сурагчдыг тэгш хамруулсан, уян хатан сургуулийн орчинг бүрдүүлэх
- Эрсдэлд өртөх магадлалтай сурагчдыг илрүүлж, зохих тусламж дэмжлэгийг үзүүлэх
- Яаралтай тохиолдолд арга хэмжээ авч, удирдан зохицуулах

Өсвөр залуу үеийнхэндээ дэмжлэг үзүүлэхээр хамтран ажиллах

Сурагчийг өндөр эрсдэлтэй нөхцөл байдалд өртөхөд нь олон хүчин зүйл нөлөөлдөг. Үүнд: гадуурхал ба дээрэлхэл, мөн онлайн дээрэлхэл; бие махбодын хүчирхийлэлд автсан эсвэл хүчирхийлэхээр сүрдүүлсэн; өөрийгөө гэмтээх буюу амиа хорлохоор оролдсон; мансууруулах бодисын буруу хэрэглээнд автсан болон зохион байгуулалттай гэмт хэргийн эсвэл бусад аюултай байгууллагуудтай холбоо тогтоосон байх зэрэг орно.

- Хүүхэддээ илрэх зан авирын томоохон өөрчлөлтүүдийг анзааран таньж олгох чухал бөгөөд онцлог үүрэг зөвхөн сургууль төдийгүй танд бас оногдож байна. Мөн тусламж дэмжлэг хүсвэл зохихыг нь хүүхэддээ ойлгуулж та түүнийг дэмжих ёстой. Хэрвээ та хүүхдийнхээ зан авирт өөрчлөлт гарч байгааг анзаарах эсвэл таны хүүхэд санаа зовох ямар нэгэн зүйлийн талаар санал бодлоо тантай хуваалцвал та дараах алхмыг хийж болно.



Тайван байж, хүүхдийнхээ ярих зүйлийг бүрэн сонсох. Хүүхдээ уг сэдвээр ярихыг нь дэмжин, энэ талаар тусламж хүсэн зөвлөгөө авах нь зүйтэй гэдгийг ойлгуулах хэрэгтэй.



Шаардлагатай бол асуулт асуун нарийн мэдээлэл авах: хэн, юу, хаана, хэзээ гэх мэт. Хүүхдээсээ өөрөө юу хийхийг мөн таниар юу хийлгэхийг хүсч байгааг асуух. Магадгүй хүүхэд тань сургуулийн ажилтантай таныг шууд ярилцахыг хүсэхгүй байж болно.



Бодол санагаа чөлөөтэй ярилцан сургуулиасаа тусламж хүсэн, зөвлөгөө авах нь өөрт нь туслах болно гэдгийг хүүхэддээ сайн ойлгуулах.



Сургуульд холбогдох мэдээллийг өгөх. Ангийн багштай уулзах цаг товлон мөн шаардлагатай бол сургуулийн захиралтай ярилцахыг хүсч болно.



Сургуулийн уулзалтууд болон тухайн асуудлыг шийдэхэд хамтарч ажиллах арга замуудыг өөртөө тэмдэглэн авах.



Сургуультай хамтран ажиллах нь асуудлыг шийдвэрлэх хамгийн зөв арга юм. Хэрвээ та хүүхдийнхээ аюулгүй байдалд ноцтой санаа зовж байвал цагдаад мэдэгдэх хэрэгтэй.



I NSW Мужийн Боловсролын Яам

Өсвөр залуу насныхны хувьд тэднийг хамгаалах хамгийн сайн хүчин зүйлүүдэд тухайн хүүхдийн бусадтай харилцаа холбоотой байгаа байдал, мөн гэр бүл, үе тэнгийнхэн болон сургуульдаа хүлээн зөвшөөрөгдөн, тэдгээрийн нэг хэсэг, гишүүн нь юм гэдгээ мэдэрсэн байх явдал юм.

Та хүүхдэдээ тусалж болох ямар арга замууд байдаг вэ?



Хүүхдийнхээ амьдралд оролцоотой байж, тэдний өдөр тутмын үйл ажиллагаа, найз нөхөд, сургууль дээрх амьдралаа тантай хуваалцах боломж олгох. Ингэснээр та хүүхдийнхээ хаана, хэнтэй юу хийдэг талаар мэдээлэлтэй байх болно.



Хүүхдээ өөрийнх нь сонирхлын дагуу аливаа хамт олны үйл ажиллагаанд оролцохыг нь дэмжих. Тухайлбал, спорт, урлаг, хобби болон зохион байгуулалттай клубууд гэх мэт.



Цахим орчинд сэрэмжтэй байх, мөн хүүхэд тань компьютер, таблет, ухаалаг гар утас зэрэг электрон төхөөрөмж хэрэглэхийн ач тус болон эрсдлийг ойлгох. Хүүхдэдээ эдгээр төхөөрөмжүүдийг ухамсартайгаар ашиглах хэрэглэхэд нь туслах.

Хүүхдээ цахим орчинд аюулгүйгээр цагийг зугаатай өнгөрүүлэхэд нь туслах тухай дэлгэрэнгүй мэдээллийг [esafety.gov.au/](https://www.esafety.gov.au/) гэсэн eSafety вэб хуудсаар авна уу.



Хүүхэдтэйгээ эерэг харилцаа үүсгэн аливаа мэдээллийг хэрхэн шүүмжлэлтэйгээр ойлгохыг өөрөөрөө харуулан, үлгэр дууриалал болох.



Хүүхдийнхээ зан авирт гарах өөрчлөлтийг анзааран, тэдэнд тантай бодол сэтгэгдлээ хуваалцахад аюулгүй гэдгийг нь мэдрүүлэх.



Хүүхэдтэйгээ шударгаар, нээлттэй ярилцахыг уриалах хэрэгтэй ба ингэснээр тэд бусдын үзэл бодлыг ойлгож, суралцах болно.

Хүүхдийнхээ асуудлыг сонсож, тэдний үзэл бодлыг ойлгохыг хичээх. Хүүхдийнхээ хэлж байгаатай та санал зөрж байсан ч хамгийн чухал нь тэд ямар ч үед хүлээн зөвшөөрөгдөх ба мөн та тэдэнд туслахад үргэлж бэлэн гэдгийг ойлгуулах юм.

Хэрэг болохуйц дараах цахим хуудсуудыг сонирхоорой

- Beyond Blue нь сэтгэцийн эрүүл мэндээ хайрлан хамгаалах тухай хүн бүрт зориулсан мэдээлэл болон тусламжийг [beyondblue.org.au](https://www.beyondblue.org.au) гэсэн вэб хуудсаар санал болгодог.
- NSW мужийн гадуурхал ба дээрэлхэлийн эсрэг вэб хуудас нь сурагч, эцэг эх, ажилтнуудад зориулсан сурагчдыг дээрэлхэлээс хэрхэн хамгаалж, арга хэмжээ авах тухай мэдээллийг [antibullying.nsw.gov.au](https://www.antibullying.nsw.gov.au) гэсэн вэб хуудсаараа дамжуулан олгодог.
- Цахим аюулгүй байдлын тухай материал болон цахим гэмт хэрэгтэй холбоотой удирдамжийг eSafety Төлөөлөгч [esafety.gov.au](https://www.esafety.gov.au) гэсэн вэб хуудсаар авна уу.



Дэлгэрэнгүй мэдээлэл

Хэрвээ та дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл харьяа сургуультайгаа холбогдоорой. Хэрвээ таньд орчуулагч хэрэгтэй бол Утсан Орчуулгын Үйлчилгээ болох 131 450 руу залган өөрийн хэл дээрх орчуулагчийг асуугаарай.

Утансы операторт холбогдохыг хүссэн дугаараа хэлэх ба оператор тухайн шугамд таны яриаг орчуулах орчуулагчийг холбох болно. Энэ үйлчилгээ нь үнэ төлбөргүй юм.